

ШАШИН БА ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

Л.Ариун*

*ХИС-ийн Сэтгүүл зүй, медиа технологийн тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D)

Түлхүүр үгс: буддын шашин, нийгмийн оюун санааны эв нэгдэл, ёс суртахуун, хэвлэл мэдээллийн нөлөө, соёл уламжлал

Аливаа орны тусгаар тогтнол үндэсний аюулгүй байдал, оюун санааны эв нэгдэлд шашин хамгийн том хүчин зүйл болдог хэмээн үздэг. Үнэхээр ч нийгмийн ёс суртахуун, соёл уламжлал, амьдралын хэв маяг, байгаль дэлхийгээ хайрлах ухаан, хүн хоорондын харилцаа зэрэг олон зүйлд шашны үзэл онол, сургаал номлол хүчтэй нөлөөлж ирсэн. Орчин үед нийгмийн оюун ухааны амьдралд шашны гүйцэтгэх үүрэг улам бүр өсөн нэмэгдэж байна. Тэр нь хүн төрөлхтний түүхийн туршид бий болж, ертөнцийг үзэх хүний нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болсоор байна, энэ салбар судлал хүмүүнлэгийн ухааны дотроос нэг чухал салбар болон дэвшин гарч байна (МУИС-ийн философи шашин судлалын тэнхим, 2019) хэмээн шашин судлаачид тэмдэглэсэн байна. Тиймээс улс үндэстний тусгаар тогтнол, аюулгүй байдал, эв нэгдэл, соёл иргэншлийн салшгүй хэсэг болсон шашны асуудлыг манай хэвлэл мэдээлэл хэрхэн мэдээлж ирсэн хийгээд хэрхэн мэдээлэх нь зүйтэй юм бэ гэдгийг энэхүү өгүүллээрээ гаргахыг зорилоо.

Улс үндэстэн бүхэн дэлхийн шашны аль нэг урсгал чиглэлийн тодорхой нөлөөнд байхын зэрэгцээ үндэсний уламжлалт шашинтай байна Монголд дорно дахин улс түмний нэгэн адил шашны уламжлал нь хүмүүсийн ахуй амьдралд гүн бат шингэж заавал даган мөрдөх ёс, зарчим болж байсан. (МУИС-ийн философи шашин судлалын тэнхим, 2019) Монгол улсын хувьд Төр сүм, хийдийн харилцааны тухай хуулийн 2-р дугаар бүлгийн 4-р зүйлийн 2-т *“Төрөөс Монголын ард түмний эв нэгдэл, соёл иргэншлийн түүхэн уламжлалаа эрхэмлэхийн үүднээс Монгол Улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзнэ. Энэ нь иргэд бусад шашин шүтэхэд саад болохгүй”* (Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль, 1993) хэмээн заасан байдаг нь бидний хувьд голлох шашин буддын шашин байна гэсэн агуулгыг хуульд тусгаж өгсөн байна. Үнэхээр ч буддын шашин бидний түүх, уламжлал, соёл ёс заншил, аж амьдрал, урлаг, хэл бичиг, уламжлалт анагаах ухаан, тоо, одон орон судлал, яруу найраг гээд олон салбар ухаанд нөлөөлж ирсэн өдгөө ч энэ нөлөөлөл хүчтэй байгаа билээ. Мөн хуулийн 2-р бүлгийн 4-р зүйлийн 1-т *“Монгол Улс дахь төр, сүм хийдийн харилцаа төр нь шашнаа*

хүндэтгэж, шашин нь төрөө дээдлэх зарчимд үндэслэнэ” (Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль, 1993) хэмээн заасан байдаг. Бас Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “3.1.4.8. Уламжлалт Бурхны шашин, соёлыг сэргээн хөгжүүлж, сүм хийдийн үйл ажиллагааг нийгмийн оюун санааг гэгээрүүлэх, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, ядуурлыг бууруулах, зовлон гамшигт нэрвээгдсэн хүн ардад туслалцаа үзүүлэх, байгаль орчныг хамгаалах үйлсэд чиглүүлэхэд төрөөс анхаарч, дэмжлэг үзүүлнэ. 3.1.4.9. Монголын ард түмний олон зуун жилийн оюуны өвийг тээж, хадгалж ирсэн Монголын Бурхны шашны өв соёлын судалгааг төрөөс онцлон дэмжинэ.” (Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010) гэх мэтээр тусгасан байдаг нь төрөөс үндэсний уламжлалт бурхны шашныг хүндэтгэн үзэж дэмжин туслах агуулгатай байна. “Төрөөс шашны талаар авч хэрэгжүүлэх бодлого, баримтлах зарчим”-ын талаар судлаач М.Амарбаяр “Эгүүр.мн” сайтад бичсэн нийтлэлдээ “Дэлхийн улс орон бүр өөрийн үндэсний соёл, уламжлал, нийгмийн сэтгэл зүйг удирдан авч явдаг шашны талаар төрөөс хэрэгжүүлэх бодлогыг зөв тодорхойлж үндэстнийхээ соёлыг түгээх, уламжлалаа хадгалахад төрөөс тодорхой зарчмыг баримтлан бодлогыг хэрэгжүүлж ажилладаг. Ардчилсан нийгмийн шинэ шатанд хүний эрхийг хангахад чиглэсэн төрийн бодлого хэрэгжүүлж байгаа боловч улс үндэстний язгуур эрх ашгийг агуулдаг, нийгмийн сэтгэл зүйг удирдан чиглүүлдэг, ард иргэдийн оюун санааны нэгдмэл ойлголтыг бий болгодог шашин, тэрхүү шашны талаарх авч хэрэгжүүлэх бодло-

го төрийн түвшинд ч, хууль эрх зүйн хүрээнд ч дутуу дулимаг байж, нийгмийн шинэ үзэгдэлд төрийн байр суурь тодорхойгүй, түүний зохицуулалт эрх зүйн хүрээнд шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн, тулгамдаж буй асуудал багагүй гарч шийдвэрлэх арга замаа хайж хариултаа хүлээж байна” (<https://eguur.mn/52409/>, 2019) хэмээсэн байна. Энэ нөхцөл байдлаас үүдэн шашны замбараагүй байдал газар авсан, шашны асуудлаар төрийн байгууллагуудын уялдаа холбоо сул, бодлого гаргагч, хэрэгжүүлэгч этгээдийн шашны талаарх ойлголт зөрүүтэй буюу нэгдсэн ойлголтгүй байдал бий болсон хэмээн шүүмжилсэн байна.

Судлаачид шашныг философийн, нийгэм судлалын /социологи/, сэтгэл зүйн, түүхийн ухааны үүднээс судлан тодорхойлсон нь бий. Энэ нь уул асуудлыг нэгтгэн дүгнэсэн үнэн зөв ойлголттой байх оюуны хэрэгцээ, шаардлагын үүднээс хийсэн ажил байх. 1992 онд баталсан Монгол Улсын үндсэн хуульд “Хүмүүнлэг ардчилсан нийгэм байгуулна” хэмээн заасан бөгөөд иргэний ардчилсан нийгэм байгуулах нь хүн төрөлхтний хөгжлийн өнөөгийн зорилттой нийлж буй хэрэг юм. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд хүний хөгжлийн тухай асуудал нэн тэргүүнд тавигдсаар байгаа билээ. Гэхдээ уламжлалт соёл, хэл, шашин, шүтлэг зан заншлаа хадгалах, хөгжүүлэх техник технологийн дэвшилд хүрэх зэрэг нь гагцхүү оюун санааны хүрээний өөрчлөлт шинэчлэлтээс шууд хамааралтай болох нь маргаангүй (МУИС-ийн философи шашин судлалын тэнхим, 2019) хэмээн манай шашин, соёл

судлалын салбарын судлаачид хэлсэнтэй санал нэг байна.

Өнөөгийн манай нийгэмд шашны асуудлыг ярьсан, шашин шүтсэн нэгнээ ялгаварлах, мухар сүсэг, тархи угаалт гэх мэтээр шүүмжлэх нь цөөнгүй. Энэ олон янзын хүчин зүйлтэй холбоотой бөгөөд олон нийтийн дунд байх энэ зөрүүтэй ойлголт буддын шашныг социализмын үед түүхийн үүднээс гуйвуулж ирсэн улбаа, Марксын онолоор “Шашин бол хар тамхи” гэсэн афоризм өнөөг хүртэл хүчтэй оршиж байгаа байдал мөн манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон шашны урсгал бие биеэ үгүйсгэх маягаар өрсөлдөж байгаа байдлаас үүдсэн буруу ташаа мэдээлэл зэрэгтэй холбоотойг судлаачид өгүүлсэн.

Буддын шашин, түүний төлөөлөгчид лам хуврагууд, сүсэгтэн олныг шүүмжлэх, гутаан доромжлох, үгүйсгэх хандлага нийгэмд маш их байгааг энэ оны 3-р сард Х богд тодорсонтой холбоотой сошиал сүлжээний мэдээллүүд, түүний сэтгэгдлүүдээс тод харагдсан. Харин мэргэжлийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд Х богд тодорсонтой холбоотой асуудлаар судлаач эрдэмтдийн үгийг олон нийтэд хүргэсэн нь богд төдийгүй бурхны шашны тухай ойлгомжтой тодорхой мэдээлэл, ойлголт авах боломж олгожээ. *ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Шашин судлалын салбарын эрхлэгч, Доктор М.Батаа* Х Богд тодорсонтой холбоотой асуудлаар gogo.mn сайтад өгсөн ярилцлагадаа “Хэвлэл мэдээллийн та бүхэн энэ талаар маш тодорхой асууж, олон нийтэд мэдээлэл өгч байгаа нь маш чухал. Барууны ертөнц сонирхоод эхэлсэн энэ үед Монголчууд эв нэгдэлтэй байж, бурхан шашны

байгууллагынхан маань алсыг харсан бодлоготойгоор шашин, соёл уламжлалаа хөгжүүлсэн, шинжлэх ухаантай хослуулсан ирээдүй рүү зорих байх. Ингэж явж чадвал Монголдоо төдийгүй дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдөнө. Энэ бол цаг хугацааны асуудал. (gogo.mn, 2023) гэсэн бол news.mn сайтад *Монгол Улсын Их Сургуулийн Антропологи-археологийн тэнхимийн багш, доктор Ж.Лхагвадэмчиг Х Богдыг тодруулж, залсан тухай ярилцлагадаа* “Монгол Улсын буддын шашинтнууд Үндсэн хуульд заасан шашин шүтэх эрх чөлөөгөө эдэлж байна. Монгол Улс иргэдийнхээ шашин шүтэх, эс шүтэх эрхийг хүндэтгэн хамгаалдаг ардчилсан улс юм байна гэдгийг дэлхийд харуулж байна. Монголын буддын шашны институцийн асуудал тодорхой болж байх шиг байна. Монгол Улсын шашин шүтэгч иргэдийн 80-аас дээш хувийг эзэлж буй буддын шашинт иргэдийн эв нэгдэлд эерэг нөлөөтэй хэмээн үзэж байна (<https://news.mn/r/2633090/>, 2023) гэсэн байна. Түүхч, судлаач доктор О.Батсайхан equuug.mn-д өгсөн “Х богдын нөлөө: Шашныг эергээр харах нь нийгмийн сэтгэлзүйд тустай” ярилцлагадаа шашны нийгэмд гүйцэтгэх үүрэг, бурхны шашны өнөөгийн байдал, иргэд олон түмэн шашиндаа хандаж буй хандлага, цаашид хэрхэн ёстойг тодорхой өгүүлсэн байсан. “Шашин үүсэхдээ тухайн эрин үеийн хүний соёл иргэншлийн нэгэн гол хэсэг болдог. Улмаар түүнийг агуулан хадгалагч хүч нь болдог гэж үздэг ажээ. Улс оронд дэг журам, тогтвортой байдлыг хангахад нийгмийн төлөвшил, ойлголцлыг илэрхийлдэг нийгмийн харилцааны баялгийг бүрдүүлэх явдал чухал байр суурь эзэлдэг. Дэлхий нийтийн жишгээс харахад,

ямар нэг үзэл баримтлал дор нэгдэж чадсан үндэстэнд нийгмийн ухамсар, иргэний ёс зүй өндөр байдаг байна. Ард түмний оюун санааг нэгтгэж байгаа тэрхүү үзэл баримтлал нь улс төрийн цэгц номлол юм уу, шашин байх нь гол биш, гагцхүү үүргээ гүйцэтгэж, нийгмийн ёс зүй ухамсрыг тогтмол дээд түвшинд барих нь л гол. Практик дээр дийлэнх улсад шашин энэ үүргийг гүйцэтгэдэг байна. Өөрөөр хэлбэл шашин нь хувь хүний ухамсар, ёс зүйн хэм хэмжээг тогтоох замаар нийгмийн ёс зүйг өргөж өгдөг ажээ. Иргэдийн өөрсдийн шашны талаарх ойлголт ийм ухвар мөчид, өнгөц байгаа нь бас нийгмийн ухамсар доройтоход нөлөөлж буй. Бусдад тусалж буян үйлдэх, хуваалцаж амьдрахын оронд хувьдаа суварга бариулдаг аминч үзлээс нь илт харагддаг. Ийм байдлаас болж буддын шашин “Бусад шашин өгдөг, буддын шашин авдаг” гэсэн ярианы сэдэв болж шүүмжлүүлж буй. Эндээс Монголын зонхилох шашин бусад шашинд байр сууриа алдаж байгаагийн гол шалтгаан нь яг буддын шашны сургаалыг таньж мэдсэн, тухайн шашныхаа сургаалыг судалж боловсорсон сүсэгтэн бараг байхгүйд оршиж байна гэж дүгнэж болно. Тиймээс шашны боловсролыг олгох замаар иргэдийн ёс зүй ухамсрыг дээшлүүлж, далимд нь амар амгалан нийгэм байгуулах нь чухал. Шашны боловсрол олгоно гэдгийг шашны сургууль нээж хүүхэд элсүүлэн лам бэлдэх бус, буддын шашны нигүүлсэнгүй, шударга, хүлээцтэй байх сургаалыг олон нийтэд таниулан сурталчлах гэж хэлсэн гэж ойлговол зохино. Үүнд хэвлэл мэдээлэл ч чухал үүрэгтэй” (<https://eguur.mn/394576/>, 2023) хэмээн маш чухал дүгнэлт санааг

хэлсэн байгаа юм. Шашны түүх судлалын томоохон төлөөлөгчийн энэхүү ярилцлагаас эшилсэн нь бурхны шашны агуулгыг хэвлэл мэдээлэл дамжуулах нь яагаад чухал вэ, ямар ач холбогдолтой вэ, хэрхэн мэдээлэх ёстой вэ гэдэгт тодорхой хэмжээгээр хариулт өгнө гэж үзэж байгаа юм. Судлаач Ж.Лхагвадэмчигийн буддизмын агуулга утга, учрыг энгийншүүлэн таниулсан “Сэтгэл тэнүүн амьдрахуй” номын өмнөтгөл үгэнд зохиолч Г.Аюурзана ““Хүн мэдэхгүй зүйлийнхээ дайсан” хэмээсэн онцгой үг бий. Хэдийгээр монголчууд зуун зууны туршид Буддизмыг дагаж шүтэж ирсэн ч дийлэнх, олонх маань Буддын гүн ухааны ч, ёс зүйн үндсийг ч голтой мэддэггүй явж ирсэн, мэддэггүй хэвээрээ үлджээ. Буддизм бол, шашныг мухар сүсгийн хэмжээнд л ойлгодог цэцэрхэгчдийн дүгнэдэгчлэн, улс орны хөгжилд чөдөр тушаа болж байгаа хоцрогдол огт биш. Харин ч хувь хүний төдийгүй нийгмийн оюун санаанд шинэ дэвшил авчрах хамгийн чухал хөшүүрэг маань юм” (Ж.Лхагвадэмчиг, 2023) хэмээсэн байна.

Энэ эшлэл манай өнөөгийн нийгэм олон нийтийн бурхны шашинд хандаж буй нийтлэг хандлага, ойлголтыг мөн хэвлэл, мэдээллийн үндсэн сэдэв, агуулга болж мэдээлэх нь ямар ач холбогдолтойг тодорхой өгүүлжээ. Олон нийтийн харилцааны онолын үүднээс доктор Б.Болд-Эрдэнэ “Нийгмийн харилцаа олон янзын хэлбэр төрхтэй. Улс төр, нийгэм, эдийн засаг, шашин шүтлэг, зан үйл, гэр бүл гээд үргэлжлүүлэн тоочих олон хэлбэр төрхтэй. Үг хэл, бичиг, үсэг, дүр дүрслэл, билэг тэмдэг, хөдөлгөөн, үйл зэрэг олон илэрц тэмдэгтэй. Ном захидал, сонин

сэтгүүл, телевиз, радио, компьютер гэсэн өөр өөр, суваг хэрэгсэлд оршдог”, мөн “Сэтгүүл зүй, реклам сурталчилгаа, PR, шоу бизнес гээд олон нийтийн харилцааны бүхий л хэлбэр зүйл иргэншсэн, даяарчлагдсан олон нийтийг нэгтгэж байна. Гэхдээ хамгийн чухал нь “”өөрөө өөрийнхөө төлөө амьдрах” сэтгэлийн хүч тэнхээ итгэл үнэмшил дүүрэн хүнийг “төлөвшүүлж” байгаад юм (Б.Болд-Эрдэнэ, 2017) гэж өгүүлсэн нь шашин нийгмийн харилцааны нэг том хэлбэр, нөгөө талаас сэтгүүл зүй, хэвлэл мэдээлэл дамжуулж буй мэдээллээрээ олон нийтийг нэгтгэж, төлөвшүүлдэг хэмээн тодорхойлсон байна.

Сэтгүүл зүйн онолын үүднээс шашныг асуудлыг хэрхэн тусгах тухай тухайлан авч үзсэн эрдэмтдийн бүтээл, судалгаа хараахан байхгүй. Гэвч хэвлэл мэдээллийн хэрэгслүүд редакцын бодлогын хувьд ардчиллын үзэл санаа, тулгуур зарчмуудыг хамгаалж, нийгмийн тэгш эрхийг дээдэлж, хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжиж, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах сэдэвт нийтлэл нэвтрүүлгүүдийг түлхүү тусгана гэсэн үзэл баримтлалтай явж ирсэн. Энэ үүднээс авч үзвэл буддын шашны сэдэв манай хэвлэл мэдээллийн хэрэгслийн томоохон сэдэв юм. Нөгөө талаас авч үзвэл нийт хүн амын дийлэнх олонхын шүтдэг бурхны шашны зөв ойлголт мэдлэг, мэдээлэл өгөх эрэлт хэрэгцээ шаардлага ч байна гэж харж байна. Хамгийн чухал нь бурхны шашны ойлголт дээр тулгуулан нийгэм олон нийтийн ёс суртахууныг дээшлүүлэх, оюун санааны түвшнийг ахиулах боломжтой хэмээн судлаачид онцлон тэмдэглэсэн байгааг анхаарах хэрэгтэй.

Бурхны шашны үндсэн сургаалуудад уур омог, шунал хүслийг тэвчих дарах тухай их гардаг. Энэ бүхнээс үүдэлтэй авлига, хээл хахууль, хулгай, ядуурал, архи тамхи, мансууруулах бодисын хэрэглээ, гэр бүлийн хүчирхийлэл, осол аваар зэрэг нийгмийн тулгамдсан асуудлууд хэвлэл мэдээллийн үндсэн том сэдэв билээ. Тиймээс бурхны шашны нигүүлсэнгүй, шударга, хүлээцтэй байх сургаалыг олон нийтэд таниулан сурталчлах замаар нийгмийн ёс суртахууныг дээшлүүлэх нөлөөг хэвлэл мэдээлэл үзүүлэх бүрэн боломжтой. Хаана нийтээрээ ёс суртахуунтай байна тэнд амар амгалан, шударга ёс, хөгжил цэцэглэл, тэгш байдал оршдог хэмээдэг.

Манай хэвлэл мэдээлэл шашны асуудлыг, тэр дундаас бурхны шашны асуудлыг хэрхэн тусгаж байгааг ажиглах зорилгоор үндэсний өдөр тутмын гурван сонин, мэдээллийн томоохон гурван сайтад ажиглалтын судалгаа хийлээ. News.mn, ikon.mn, gogo.mn мэдээллийн сайтуудад тодорхой түлхүүр үгсийн хайлтаар; өдөр тутмын “Өдрийн сонин”, “Зууны мэдээ”, “Өнөөдөр” сонины сүүлийн гурван сарын дугааруудад буддын шашин, ер нь шашны сэдвээр нийтлэгдсэн бүх материалуудыг шүүн үзлээ. Юуны өмнө шашны сэдэв хэвлэл мэдээллээр маш бага гардаг нь харагдаж байна. “Өнөөдөр” сонин гэхэд сүүлийн гурван сарын дугаарт мэдээ, сурвалжилга, ярилцлагын 5 бүтээл нийтэлсэн байна. “Өдрийн сонин” харьцангуй олон буюу 11 материал гаргасны дийлэнх нь буддын шашны сэдвээр судлаач мэргэжилтнүүдээс дэлгэрэнгүй ярилцлага авсан, Ромын папын айлчлал, Даншиг наадмын тухай дэлгэрэнгүй сурвалжилга хийж гаргажээ. Сайтуу-

дын хувьд “Шашин”, “Гандан”, “Лам”, “Сүсэгтэн”, “Богд” гэх мэт үгээр хайлт хийж түүсэн ба он цагийн хувьд сүүлийн таван жилийн материалуудыг сонгож авч ажигласан. Нийтлэг ажиглаж байгаа зүйлс нь “Даншиг наадам болно”, “Бурхан багшийн их дүйчин өдөр тохионо” гэх мэт үйл явдлын товч мэдээ байх агаад энэ жилийн 6-р сард болсон Лам хүүхдийн хүчингийн хэргийн тухай бүх л хэрэгслүүд хэдэн өдөр дараалан мэдээлжээ. Мөн энэ жилийн томоохон үйл явдал Ромын Папын айлчлалын сурвалжилга, ярилцлага зэрэг даацтай материалууд, Х Богд тодорсонтой холбоотой тодруулга ярилцлага судалгаа хийсэн бүх хэвлэлүүдэд ямар нэг хэмжээгээр байна.

Дээрх гурван томоохон үйл явдал болоогүй бол бурхан ном, гандан хийд, лам, сүсэгтэн олны тухай мэдээлэл маш хомс байдаг нь 4-5

жилийн өмнөх сайтуудын мэдээллээс харж болохоор байна. Үнэхээр манай хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, сэтгүүлчид шашны талаар ойлголт мэдлэг байхгүй байна, мөн зөв талаас нь өөрөөр хэлбэл өв соёл талаас нь ярьж таниулдаг хэв загвар алга. Нэг бол үйл явдлыг дурдсан төдий мэдээ, нөгөө бол гандан хийд, лам хуврагийг буруутгасан, шүүмжилсэн, лам нартай холбоотой хэрэг зөрчлийн мэдээг дуулиан шуугиан болгосон байдлаар мэдээлж байгаа нь харагдаж байна. Зүй нь буддын шашныг бидний өв соёл, уламжлал, өнөөгийн бидний нийгэмд нэн хэрэгтэй байгаа ёс зүй, ёс суртахууныг номлодог, эрдэмтэн мэргэдийн тусгаар тогтнолд оруулсан хувь нэмэр, лам нарын сурч боловсордог арга барил, ховор нандин өв уламжлал тээж ирсэн гэдэг талаас нь харуулах ёстой мэт санагдана.

	2023-08-01 2023-10-20	2023-08-01 2023-10-20	2023-08-01 2023-10-20	2016-2023	2017-2023	2022-2023	нийт
	Өнөөдөр сонин	Өдрийн сонин	Зууны мэдээ	ikon.mn	gogo.mn	news.mn	
Хандлага	5	11	10	27	39	44	136
Төв	2	5	10	19	21	17	74
Эерэг	3	6	0	2	8	19	38
Сөрөг	0	0	0	6	10	8	24
Сэдэв	5	11	10	27	39	44	136
түүх, шинжлэх ухаан судалгаа, зан үйл	1	2	2	11	11	16	43
хэрэг зөрчил	0	0	0	4	10	8	22
БОГД	0	4	0	0	2	7	13
Пап	0	3	8	3		7	21
Хамба	3	2		2		4	11
Улс төр	0	0	0	7	0	1	8
Гадаад мэдээ					7		7
аялал жуучлал	0	0	0	0	4	0	4
эрх зүй	0	0	0	0	3	0	3
орчин	1	0	0	0	1	1	3
номын айлдвар	0	0	0	0	1	0	1
Төрөл зүйл	5	11	10	27	39	44	136
Мэдээ	2	0	2	10	28	25	67
Сурвалжлага	2	4	8	4	4	6	28
Ярилцлага	1	5	0	11	7	8	32
Өгүүлэл	0	1	0	0	0	4	5
Фото зураг	0	1	0	1	0	1	3
Тайлбар	0	0	0	1	0	0	1

Хүснэгт №1. ОНМХ-үүдийн шашны талаар нийтэлсэн бичвэрийн тоо. Хандлага, сэдэв, төрөл зүйлээр.

2020 оны “Хүн ам, орон сууцны тооллого”-ын дүнгээр нийт шашин шүтэгч Монгол Улсын иргэдийн 86.2 хувь нь буддын шашин шүтдэг гэсэн статистикийн тоо байна. Бүр нарийвчилбал манай улсын 15 наснаас дээш хүн амын 60.0 хувь нь шашин шүтдэгээс 90.0 орчим хувь нь буддын, 5.4 хувь нь мусульманы, 4.2 хувь нь бөөгийн, 2.2 хувь нь христийн шашин шүтдэг (Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2020) гэсэн судалгаа гарчээ. Энэ **хэмжээгээр буддын шашны нөлөө нийгэмд байна гэсэн үг**. Нөгөө талаар шүтдэг шашныхаа талаар зөв мэдээлэл авах, мэдлэг ойлголтоо улам нэмэгдүүлэх, ёс суртахуун, сахилга батаа улам сайжруулах хэрэгцээтэй хэрэглэгч байна гэдгийг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд анхаарах хэрэгтэй. Эдгээр хэрэглэгчдэдээ зориулаад буддын шашны тухай мэдээ мэдээлэл түгээх орон зай байгаа нь харагдаж байна. Мөн хэвлэл мэдээлэл нь нийгмийг соён гэгээрүүлэх, зохион байгуулалтад оруулахад нөлөө үзүүлдэг хамгийн хүчтэй

хэрэгсэл. Энэ чанараа ашиглан буддын шашны үндсэн сургаал болох ёс зүйтэй зөв хүн байх, бусдад туслах, бусдыг энэрэх, асрах, бусдын оронд өөрийгөө тавьж үзэж ойлгох, хамаг бүхийг эх буюу өөрийн ээж шигээ бодож хайрлах, байгаль дэлхийгээ хайрлах, хамгаалах гээд ёс суртахууны хэм хэмжээ, ёс зүйтэй амьдралыг нийгэмд түгээхэд хувь нэмрээ оруулах нь өнөөгийн энэ цаг үед үнэхээр чухал байгаа юм. Энэ мэдээллийн хэрэгцээг гандан хийдүүд, шашны төвүүд, лам хуврагуудын фейсбүүк пэйж хуудаснууд хангаж байна. Гэвч эдгээр нь судрын үгээр, шашны нарийн ойлголтоор, эсвэл зан үйл төдийгөөр хязгаарлагдаж байгаа тул олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үндсэн арга барилын дагуу олон түмэнд ойлгомжтой, хүртээмжтэй, сонирхолтой хэлбэрээр хүргэж хувь хүний ухамсар, ёс зүйн хэм хэмжээг тогтоох замаар нийгмийн ёс зүйг сайжруулах хэрэгцээ шаардлага байна.




График №1. ОНМХ-үүдийн шашны талаар нийтэлсэн мэдээллийн төлөв.

Нийгэм олон нийтийн хандлагаас улбаалан судлаачийн хувьд шашин, сүм хийд, лам нарын тухай мэдээлэл дийлэнх нь сөрөг байх болов уу гэсэн таамаглал

байсан ч хэвлэлд гарч буй мэдээлэл голдуу үйл явдлын мэдээ байсан тул ийнхүү төвийг сахисан хандлагатай байлаа.




График №2. ОНМХ-үүдийн шашны талаарх мэдээллийг сэдвээр ангилсан байдал.

Сэдвийн хувьд дийлэнх нь түүх, шинжлэх ухаан, судалгаа, шашны зан үйлийн тухай холимог агуулга бүхий мэдээллүүд байна. Х богд тодорсон-той холбоотойгоор “Х Богд Жавзандамба хутагт” гэсэн бие даасан сэдэв болж орж ирсэн нь хэвлэл мэдээлэл шашны асуудлыг сонирхох болж, энэ сэдвээр судлаач, эрдэмтдийн даацтай үгийг олон нийтэд хүргэх, энэ сэдвээр

ч дамжиж бурхны шашны тухай илүү дэлгэрэнгүй зөв ойлголт мэдээлэл авах үндэс болжээ хэмээн дүгнэсэн. Мөн Ромын Пап ламын айлчлалын мэдээ, сурвалжилга бүхий л хэвлэл мэдээллийн хэрэгслүүд маш их ач холбогдол өгч мэдээлсэн. Хамба лам ажил, албан тушаалаа хүлээлгэн өгөхтэй холбоотой мэдээлэл сүүлийн үед түлхүү байлаа.




График №3. ОНМХ-үүдийн шашны сэдэвт нийтлэлийг сэтгүүл зүйн бичлэгийн зүйлээр ангилсан байдал.

Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйлээр авч үзвэл үйл явдлын мэдээ голдуу байсан ба Даншиг наадам, Ромын Папын тухай мэдээ, сурвалжилга гарч байна. Хэд хэдэн даацтай

ярилцлага гарсны дийлэнх нь Х богдын тухай мэргэжлийн судлаач эрдэмтнээс тодруулсан ярилцлага байлаа.

Энэ бүхнээс манай хэвлэл мэдээлэл Монгол орны зонхилох шашин хэмээн үндсэн хуульдаа тунхагласан буддын шашны асуудлыг хэрхэн тусгаж байгаа ерөнхий дүр төрх харагдаж байгаа юм. Шашны сэдвээр бичих нь анагаах, эрүүл мэнд, экологи, эдийн засаг гэх мэт нарийн, ээдрээтэй ойлголт бүхий салбар ухаануудын адил энэ чиглэлээр мэргэшсэн сэтгүүлчийн хийх ажил. Сэтгүүл зүйн мэдээлэл дамжуулах зарчмын дагуу хэт нэг талыг барин сурталчлахгүй, бусад шашныг ялгаварлахгүй, эрх тэгш хандах, мэдээж хэрэг баттай эх сурвалж дээр үндэслэн аль болох бодит байдалд нийцсэн мэдээлэл түгээх учиртай. Ойлголт багатай сэтгүүлчийн бүтээл шашны зан үйлийг түлхүү харуулж, бодит байдлаас хэтийдсэн мэдээлэл дамжуулж, шашныг хэт магтан дуулсан, эсвэл мэт муушаан буруутгасан байх эрсдэлтэй. Хамгийн чухал нь шинжлэх ухааны судалгаа нотолгоо дээр суурилсан мэдлэг мэдээлэлд тулгуурлан нийтийн ёс суртахууныг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулах шаардлага, эрэлт хэрэгцээ байна хэмээн харж байна.

Түүнчлэн бурхны шашны ойлголт дээр тулгуурлан нийгэм олон нийтийн ёс суртахууныг дээшлүүлэх, оюун санааны түвшнийг ахиулах боломжтой хэмээн судлаачид онцлон тэмдэглэсэн байгааг анхаарах хэрэгтэй.

Буддын шашныг бидний өв соёл, уламжлал, өнөөгийн бидний нийгэмд нэн хэрэгтэй байгаа ёс зүй, ёс суртахууныг номлодог, эрдэмтэн мэргэдийн тусгаар тогтнолд оруулсан хувь нэмэр, лам нарын сурч боловсордог арга барил, ховор нандин өв уламжлал тээж ирсэн гэдэг талаас нь харуулах ёстой мэт санагдана.

Сэтгүүл зүйн хэрэглэгч талаасаа ч тэр буддын шашны нөлөө манай нийгэмд өндөр, энэ сэдвээр зөв мэдээлэл авах, мэдлэг ойлголтоо нэмэгдүүлэх, ёс суртахуун, сахилга батаа сайжруулах хэрэгцээтэй хэрэглэгч цөөнгүйг анхаарах хэрэгтэй. Тиймээс хүн амын дийлэнх олонхын шүтдэг бурхны шашны ойлголт мэдлэг, мэдээлэл авах эрэлт хэрэгцээ шаардлагад тулгуурлан нийгмийн ухамсар ёс зүйг дээшлүүлэх нь хэвлэл мэдээллийн салбарын бид бүхний хийх ёстой ажил, үүрэг мэт санагдана.

Эшлэл болон Ашигласан бүтээлийн жагсаалт

1. gogo.mn. (2023 оны 3 сарын 11). М.Батаа: *Х Богд уламжлалт шашин ном, орчин үеийн өндөр боловсрол эзэмшсэн гэгээнтэн болох байх.* М.Батаа: *Х Богд уламжлалт шашин ном, орчин үеийн өндөр боловсрол эзэмшсэн гэгээнтэн болох байх.* <https://alpha.gogo.mn/r/k8x0m>
2. <https://eguur.mn/394576/>. (2023 оны 3 сарын 11). О.Батсайхан: *Х богдын нөлөө: Шашныг эергээр харах нь нийгмийн сэтгэлзүйд тустай.* О.Батсайхан: *Х богдын нөлөө: Шашныг эергээр харах нь нийгмийн сэтгэлзүйд тустай.* <https://eguur.mn/394576/>
3. <https://eguur.mn/52409/>. (2019 оны 12 сарын 6). Төрөөс шашны талаар авч хэрэгжүүлэх бодлого, баримтлах зарчим. *Төрөөс шашны талаар авч хэрэгжүүлэх бодлого, баримтлах зарчим.* <https://eguur.mn/52409/>
4. <https://news.mn/r/2633090/>. (2023 оны 3 сарын 14). “Х Богдыг тодруулснаар Монгол ардчилсан улс гэдгээ харууллаа”. *“Х Богдыг тодруулснаар Монгол ардчилсан улс гэдгээ харууллаа”.* <https://news.mn/r/2633090/>
5. Б.Болд-Эрдэнэ. (2017). *Олон нийтийн харилцаа.* Улаанбаатар.

6. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай үзэл баримтлал (2010).
<https://legalinfo.mn/mn/detail/6163>
7. Д.Нарантуяа. (2021). *Редакцийн зурвас*. Улаанбаатар.
8. Ж.Лхагвадэмчиг. (2023). *Сэтгэл тэнүүн амьдрахуй*. Улаанбаатар.
9. МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим. (2019). *Шашин судлал*. Улаанбаатар.
10. О.Батсайхан. (огноо байхгүй). Х богдын нөлөө: Шашныг эергээр харах нь нийгмийн сэтгэлзүйд тустай.
<https://eguur.mn/394576/>
11. Статистикийн мэдээллий нэгдсэн сан (2020).
<https://www2.1212.mn/BookLibrary.aspx?category=001>.
12. Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль (1993 оны 11 сарын 11).
<https://legalinfo.mn/mn/detail/485>.

Талархал

Энэхүү судалгааны өгүүллийг бичихэд онол арга зүйн зөвлөгөө өгсөн:

- МУИС-ийн Сэтгүүл зүйн профессор, доктор Б.Болд-Эрдэнэ
- Сэтгүүлч Д.Нарантуяа
- МУИС-ийн шашин судлалын тэнхимийн багш, судлаач С.Дэмбэрэл

Судалгааны эх хэрэглэгдэхүүн болгож сонины цахим хувилбараа илгээсэн:

- Зууны мэдээ сонины эрхлэгч Д.Отгонбаяр
- Өнөөдөр сонины Тамгын газрын дарга Ц.Болормаа
- Өдрийн сонины сэтгүүлч Б.Номин-Эрдэнэ нарт талархал илэрхийлье

Summary

Religion is undeniably one of the most significant factors that influence a nation's sovereignty, national security, and spiritual unity. The impact of religious factors

extends to various aspects of society, including social morality, culture, traditions, lifestyles, love for nature, and human relationships. In the modern era, the role of religion in shaping social and intellectual life is increasingly prominent. Therefore, this article aims to explore how the mass media has previously handled religious matters and how it should approach them in the future.

Promoting Social Morality through Religious Education: Religion plays a pivotal role in elevating social morality by establishing the ethical norms that guide individual consciousness. Thus, promoting religious education becomes essential for creating a peaceful society with heightened moral awareness. It's important to note that religious education doesn't solely involve establishing religious schools and enrolling students; it's about reaching out to the public and introducing the teachings of Buddha on compassion and tolerance. Mass media can serve a vital role in this endeavor.

Media's Coverage of Buddhism and Religion: To assess how the press covers religious matters, especially those related to Buddhism, I conducted a study involving three national daily newspapers and three major media websites. The findings revealed that our media outlets and journalists often lack a comprehensive understanding of religion. Furthermore, they struggle to present religious matters as integral components of our cultural and spiritual heritage. Typically, mass media tends to focus on sporadic events or sensational critiques of clergy and priests. It is imperative that we approach religious matters in terms of their significance to our cultural heritage, traditions, ethics, morality, the contributions of religious leaders to our struggle for independence, and their lasting spiritual and pedagogical legacies.

Keywords: Buddhism, spiritual unity of society, morality, influence of media and culture.